



26

ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 11/3

Шивээговь сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 08 дугаар “Сумын 2023 газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2 дугаар баг, Хөтлийн ухаан энгэрт байршилтай 700 м² газрыг “Төрийн захиргааны байгууллага”-ын зориулалтаар Засаг даргын Тамгын газарт 60 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмшигч Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмшигч Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Сугармаатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА
Данченж П.ГАНЧИМЭГ

42123 024